



ИРГЭНИЙ НИЙГЭМ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ СУБЪЕКТ МӨН: ОХУ, АНУ-ЫН ТУРШЛАГА

Б.Нэргүй¹

¹ Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн
Цахим шуудан: nergui_ids@yahoo.com

Abstract: Abstract: A civil society in the security sector is main element of social reform. One of the important issues of the civil society in the security sector in the democratic society is to be increased the participation of “civil society” in the development and implementation process of the national security and defense policy.

Civil society is composed of the totality of many voluntary social relationships, civic and social organizations, and institutions that form of the basis of functional society, as distinct from the force-backed structures of the state.

The civil society would not be opposed to the state. The activities and operations of the civil society might be possible to implement in the situations of the democratic society relations, in regarding too basis of the strengthened basement of the civil society establishment. Accordingly, that civil society is possible to develop elsewhere, that would be established strengthening possibility. Otherwise a civil society was developed elusively, when that is placed by the concurrence authoritarian and totalitarian condition.

Civil society activities as subject provides different impact on ensure safety academic papers are a new area of security studies. Civil society’s participation in the security sector’s learning from the experience of the United States and Russia.

Keywords: ардчилал, иргэний нийгэм, аюулгүй байдал, хөдөлгөөн, хямрал, хүн, эрх чөлөө, хөгжил, дэвшил, олон нийт, ашиг сонирхол, үнэт зүйл.

ОРШИЛ

Ардчиллыг орчин үеийн эрдэмтэн, судлаачдын дийлэнх нь дотоод ба гадаад хүчнүүдийн хоорондын зөрчил (мөргөлдөөн)-ийг шийдвэрлэх тогтолцоо хэмээн үзэх болов [10]. Тийм учраас ардчилал бол өнөөгийн эрин үед илүү тохирсон улс төрийн дэглэм хэмээн хүлээн зөвшөөрчээ. Үүний зэрэгцээ аюулгүй байдал ба ардчиллын өнөөгийн зөрчил нь даяаршлын нөлөөгөөр хурцдаж төрийн болон хувь хүн, иргэний нийгмийн зүгээс үндэсний аюулгүй байдлын парадигмыг илүүтэй ойлгохыг шаардаж, шинэ үзэл, хандлага гарах болов. Орчин үеийн ардчилсан төр улсууд үндэсний аюулгүй байдал хэмээх ухагдахууныг хувь хүн,

нийгэм төрийн эрх, эрх чөлөө, аюулгүй байдал хангагдаж, тэдгээрийн харилцан уялдаатай цогц хөгжил баталгаажсан нөхцөл байдал гэж тайлбарлаж байна. Иймээс ардчилсан төр улс, иргэний нийгэм болон хувь хүний харилцан зохицолдсон үйлчлэлийн тэр хэмжүүрийг тодорхойлох шаардлагатай. Ялангуяа Үндсэн хуулиндаа “...хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго...” болгож, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)-даа үндэсний аюулгүй байдлыг төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаанд тулгуурлаж хангах шинэ зорилт дэвшүүлсэн нь Монгол орны хувьд нэн тулгамдсан судалгааны чиглэл болоод

байна.

Үндэсний аюулгүй байдлын хамрах хүрээ өргөжин тэлж, аюулгүй байдлын шинэ субъект бий болон, тэдгээрийн үйл ажиллагааны цар, шинж төлөв өөрчлөгдөж байна. Э.Ротшильд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг илүү өргөн агуулгаар авч үзэн “төрөөс доошлоод хувь хүн”, “төрөөс дээшлээд биосфер”, “цэргийн аюулгүй байдлаас улс төр, эдийн засаг, нийгэм, экологийн аюулгүй байдал”, “төрөөс дээшлээд олон улсын институт хүртэл, доошлоод бүс болон орон нутгийн засаг захиргаа, улмаар төрийн бус байгууллага, олон нийтийн санал бодол, хэвлэл мэдээлэл, байгалийн болон зах зээлийн хийсвэр хүч хүртэл” дөрвөн хэмжээст загварыг гаргасан байдаг [20.55]. Энэ загвараас үндэсний аюулгүй байдал, улс төрийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахад янз бүрээр нөлөө үзүүлдэг аюулгүй байдлын шинэ субъект болох иргэний нийгмийн үйл ажиллагаа аюулгүй байдлын онолын судалгааны шинэ чиглэл болоод байна.

Төр, иргэний нийгмийн үндэсний аюулгүй байдлын хүрээн дэх харилцан үйлчлэлийн үндсэн асуудлыг хэд хэдэн чиглэлээр багцлан үзэж болох юм. Зарим судлаачид [5; 11] иргэний нийгмийн талаарх өөрийн үзэл бодлоо А.Де. Токвиль [12], Р.Патнэм [17] болон бусад онолчдын байр суурины хүрээнд хөгжүүлж байна. Тэд өөрсдийн бүтээлдээ иргэний нийгмийн үндэс бол аль нэг хэсэг бүлгийн эд эс болж байгаа хувь хүн бөгөөд тэрээр нэгдэл, эвсэл, холбоо болон өөр бусад хэлбэрийн байгууллагаар дамжуулан өөрийн олон талт ашиг сонирхол, эрэлт хэрэгцээ, боломж, чадавхиа хэрэгжүүлдэг. Тийм учраас иргэний нийгэм төр засгийн дотоодод ардчиллын хэм хэмжээ, үйл ажиллагаа итгэлцэл, хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, тэсвэр тэвчээр, олон нийтийн харилцан туслалцаа, улс төрийн идэвх зэрэг ойлголтод тулгуурладаг бөгөөд тэдгээр нь цогц байдлаар “хүний капитал”

гэгдэх ардчилсан нийгмийн аюулгүй байдлын судалгааны хөгжлийг бүрдүүлэх хүчин зүйл болдог байна.

Олон улсын судлаачид иргэний нийгмийн төр, иргэний аюулгүй байдалд үзүүлэх нөлөө нь нэг талаас эерэг, нөгөө талаас сөрөг байж болно гэж үздэг. Т.Карозерс [13], Д. Фернандо, А.Хестон [14] нар иргэний нийгэм нь дан ганц эерэг шинжийг агуулсан институт биш юм. Гэвч улс төрийн десруктив бүлгүүдээр дамжуулан тэрбээр аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж, өөрийн ашиг сонирхол, хэрэгцээг ямар ч хамаагүй арга хэрэгслээр хэрэгжүүлэхийг санаархдаг гэсэн байна. Д.Райли үүнтэй холбогдуулан Дэлхийн хоёрдугаар дайны өмнө Италид гарсан үндсэрхэг хөдөлгөөнийг нэрлэсэн байна [18].

Л.И.Никовскаягийн тэмдэглэснээр социум дотор иргэний нийгэм төртэй харилцан үйлчлэлцэх эргэх холбооны институт буюу түүнд хяналт тавих нийгмийн үйл явцыг оновчлох институт болж үүсдэг бүтэц мөн. Гэхдээ төр ба иргэний нийгмийн харилцан үйлчлэл нь “иргэний хүрээн дэх олон ургальч байдал, төрийн засаглалын тусгаар тогтнох эрмэлзэлийн хооронд байнгын зөрчлийг үүсгэж байдаг” [7.7]. Энэ зөрчил нь хамтран ажиллах, гэрээ хэлцэлээс эхлээд илэрхий сөргөлдөөн ба иргэний үл захирагдах үйлдэл хүртэл төрөл бүрийн хэлбэрээр илэрдэг байна. Энэ байдал хямралын (төрийн, эдийн засгийн, улс төрийн зэрэг) нөхцөл байдалд онцгой илүүтэй өрнөдөг ба улмаар эрх ашгийн огцом эсрэгцэлд хүргэж, нийгмийн социаль бүтцийг тэнцвэргүй байдалд оруулдаг.

Орчин үед нийгмийн хямралт үзэгдэл ихээхэн ажиглагдаж байгаа бөгөөд түүний нэгэн илрэл нь даяаршлын нөлөөгөөр үндэсний аюулгүй байдлыг хангахад учирч буй эрсдэл болох төрийн хямралыг энд нэрлэж болно. Энэ хямрал нь иргэдийн үл захирагдах байдал, улс төрийн цөхрөлөөр илэрдэг байна. Үүнийг зарим судлаачид ардчиллын сөрөг тал ч



гэж нэрлэж байна. К.Макферсон орчин үеийн улс төрийн нөхцөл байдлыг “улс төрийн элит ба цөхрөлд орсон сонгогчдын өрсөлдөгч тогтолцоо” гэж дүрсэлсэн байна [4.150]. Эл байдал нь заримдаа улс төрөөс зайлуулагдсан ч өөртөө сонгогдох эрхийг олж авахыг хүсэгч ардчиллын эсрэг радикал (эрс хатуу) хүчний төлөө эсэргүүцлийн аянд хүргэдэг. “Stratfor” сайтын “хямралт байдлын мэдээ” буланд бичигдсэнээр долоо хоног бүр дэлхий даяар мянга мянган эсэргүүцлийн акц (явуулга) [21] болж байдгийн дотор шашны хуучинсаг үзэлтний эсэргүүцлийн хөдөлгөөн, Уолт-Стрит ажилгүйчүүдийн хөдөлгөөнийг нэрлэж болно. Иймэрхүү эсэргүүцлийн акц (явуулга) нь иргэний нийгмийн тодорхой хэсэг бүлгийн байр суурийн илэрхийлэл болж, төрийн үндэсний аюулгүй байдалд сөрөг үр дагаварыг бий болгодог байна.

К.Крауч “хэрэв тэдний энэ хөдөлгөөн олон нийтийн зүгээс ямар нэг дэмжлэг авбал тэр нь өргөжин жирийн хүмүүсийн дуу хоолой болж, хэн нэгний далбаан дор тэмцэлд босоход хүргэдэг” гэж бичсэн байдаг [3.145]. Энэ тохиолдолд төр нь засгийн эрх барьж буй улс төрийн элитийн нэрийн өмнөөс иргэний нийгмийн тодорхой хэсэг бүлэгтэй сөргөлдөхөд хүрч, тэр нь ихэвчлэн нийгэм төрийн тогтворгүй байдлыг үүсгэдэг. Үүний жишээ бол Арабын ертөнцөд ээлж дараалан гарч буй эсэргүүлийн акц бөгөөд тэр нь улмаар илэрхий сөргөлдөөн болон хувирч “Арабын хавар”-т хүргэж, иргэний дайн гарахад ч хүргэсэн байдаг. Төр нийгмийн тодорхой хүрээнд үүссэн асуудлыг шийдвэрлэхэд

хүчин мөхөсдөх тохиолдолд энэ үүргийг жирийн иргэд өөр дээрээ хүлээн өөрсдийн аюулгүй байдлыг хангахын тулд түрэмгий харгис арга хэрэгсэл ашиглах тохиолдолд төр, нийгэм, хувь хүний тогтвортой байдалд аюул учрах болно. Энд Норвегийн аймшигт жишээ, дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэхэд төрийн хүч сул байгааг хараад өөрөө бие даан хэргийн учрыг олохоор шийдэж арал дээр өвсөр насныхныг буудан хөнөөсөн А.Брейвикийн² үйлдлийг дурдаж болох юм. Ийнхүү иргэний нийгэм ардчилал, аюулгүй нийгмийг бүрэлдүүлэн тогтоох бат суурь болж тэр бүр чаддаггүй төдийгүй улс төрийн захиргаалтын дэглэм тогтох бололцоог бий болгодог байна. Захиргаалтын төрийн хувьд зан суртахууны үнэт зүйлс: буяны өглөгийн, сайн дурын экологийн хөдөлгөөн зэрэг нийгмийн улс төрийн биш асуудалд иргэний нийгэм анхаарлаа хандуулдаг ажээ.

Гэсэн ч иргэний нийгэм туйлын ноёрхолд хүрэхийг эрмэлзэх улс төрийн засаглалыг “тогтоох ба тэнцвэржүүлэн барих” тогтолцооны үр нөлөөтэй хэрэгсэл болдог. Тиймээс үндэсний аюулгүй байдлыг хангахын тулд төрийн засаглалын бүтцэд нөлөөлөн нийгмийн асуудлыг шийдвэрлэн, төр нийгэм, хувь хүний тогтвортой хөгжлийг хангаж чадахуйц иргэний нийгмийн тийм технологийг олох шаардлагатай.

Аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд төрийн алдагдсан эл байр суурийг хамтын ажиллагааг хөгжүүлсний үр дүнд л эгүүлэн тогтоох боломжтой.

1. <https://www.stratfor.com/> Stratfor нь 1996 онд Жорж Фрийдмэний санаачлагаар байгуулагдсан 5 чигэлээр үйл ажиллагаа явуулдаг ферм юм. Үүний нэг болох энэхүү сайт нь дэлхий дахины мэдээнд суурь анализ хийж, цаашидын чиг хандлагыг тодорхойлсон мэдээллээр хэрэгчлэгдийг хангахаас гадна, геополитикийн тагнуул, улс төр, эдийн засаг, цэрэг-батлан хамгаалах асуудлаар үйл ажиллагаа явуулдаг байна.
2. 2012 оны 7 дугаар сарын 22-нд Норвегид 77 хүний аминд хүрсэн хэт үндсэрхэг үзэлт Андерс Брейвик хийсэн үйлдлээ хүлээж байгаа ч өөрийгөө буруугүй хэмээн мэдэгдсэн. “Олон талт соёлыг дэмждэг урвагчид ард түмэн, соёл, эх орныг минь аюулд оруулаад байгаа үед би хөдөлсөн. Тэд бол Норвегийг устгаж байгаа хүмүүс. Тиймээс миний хийсэн үйлдэл буруу биш. Ослод болсон дэлбэрэлт бол тэдгээр урвагчдын эсрэг сануулга байсан. Тэд норвеги үндэстнийг устгаж байна” хэмээн шүүхийн танхимд мэдэгдэж байсан. Брейвик долдугаар сарын 22-нд Осло хотын Засгийн газрын байрны гадаа бөмбөг дэлбэлж найман хүний аминд хүрснийхээ дараа нийслэлээс 45 км-ийн зайд байдаг Утойя арал дээр очиж 69 хүнийг буудан алсан билээ.

“Төр-иргэний нийгэм”-ийн харилцааг А.Ю.Сунгуров шинжлээд ардчилсан улс төрийн тогтолцооны нөхцөлд хамгийн үр ашигтай бүдүүвч бол “нийгэмд түншлэлийн харилцаа” тогтоох явдал гэж үзсэн байна. “Засаглалын хариуцлагатай төлөөллүүд олон нийтийн хяналтийг хамгийн чухал болохыг ойлгосон байх нь энэ загварын оршин тогтнох гол хэмжүүр” мөн [11.2].

Энэ өнцөгөөс харвал ардчилал, иргэний нийгмийн байгуулалтын хүрээнд АНУ-ын хуримтлуулсан олон жилийн туршлага сонирхолтой бас сургамжтай. Үндэсний аюулгүй байдлын стратегитаа Б.Обама [15] үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог дэлгэрэнгүй тусгасан байдаг. Өнөөдөр иргэдийн 70 гаруй хувь нь аюулгүй байдлыг хангах тогтолцооны үнэ цэнэтэй субъект болж, төр засгийн үйл ажиллагааны төрөл бүрийн салбарт ажиллаж буй өөрөө зохион байгуулагдсан аль нэг хэлбэрт оролцож байна. Эдгээрт зах хязгаарын болон бүс нутгийн түвшинд зарим эрхийг шилжүүлэн өгчээ. Хүмүүсийн нийтлэг болон арилжааны бус байгууллага бол аюулгүй байдлыг хангах үүрэгтэй төдийгүй аюулгүй байдлыг цогцлоон үндэсний аюулгүй байдлын шинэ бодлогыг бүрдүүлэгч гэж тооцогддог байна. АНУ-д иргэд, арилжааны бус сектор, хувийн компани, иргэний нийгмийн институт цөм улс төрийн бодлогын бүрэн эрхт субъект болж “сэтгэлгээний үйлдвэрлэл” болон судалгааны хүрээлэн, эрдэм шинжилгээний бусад байгууллагаар дамжуулан улс төрийн бодлогын стратегийг боловсруулахад оролцдог. Батлан хамгаалах яамны бүтэц, цэргийн мэргэжлийн байгууллага, зэвсэгт хүчинд олон тооны энгийн мэргэжилтнүүд ажилладаг. Бизнесийн хүрээнийхэн, шинжлэх ухааны судалгааны хүрээлэн, засгийн газрын бус байгууллагаас цэрэг-улс төрийн элитэд сонгон шалгаруулалт хийхийн сацуу эргүүлээд уг салбараас дээрх байгууллагууд руу шилжүүлэх ажил байнга хийгдэж байдаг. Ингэж иргэний

болон цэргийн салбарынхан нийтлэг ажил үйлс, ашиг сонирхлоороо өөр хоорондоо холбогдож, иргэний нийгэм болон төрийн харилцааны хөгжилд эерэг нөлөө үзүүлж иржээ.

Үүний зэрэгцээ энэ тогтолцоо нь өөртөө эрсдэлийг агуулж байдаг. Учир нь ардчилсан тогтолцоо бүрэн төгөлдөржөөгүй өнөөгийн нөхцөлд хувь хүмүүсийн авилгал, ашиг сонирхлын лобби зэрэг сөрөг үзэгдэл гарч болзошгүй юм. Ийм нөхцөл байдал бий болохоос иргэний хяналтын үр нөлөө бүхий механизм урьдчилан сэргийлж, төр болон эрх баригч элитийг үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн шийдвэр гаргуулахгүй байх бололцоог олгодог. Б.Обамагийн стратегид аюулгүй байдлын тогтолцооны “тунгалаг бүтэц”-ийг бий болгон, АНУ-ын холбооны төсөвт болон аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээсэн түшмэлүүдийн үйл ажиллагаанд тавих бодитой хяналтыг хэрэгжүүлэх саналыг дэвшүүлсэн байдаг. АНУ-ын стратегийн сүүлийн энэ шинэ чиглэл нь төрийн томоохон байгууллагыг бодвол үндэсний аюулгүй байдлыг илүү үр ашигтай хангах оролцогчийн хувьд төр ба иргэний нийгмийн харилцан үйлчлэлийн технологид баримжаалсан гэж үзэж болохоор байна. Ялангуяа аюулгүй байдлын үнэт зүйлс, түүний дотор аюулгүй байдлын соёлыг бүрдүүлж төлөвшүүлэхэд онцгой анхаарч байна.

ОХУ-д үндэсний аюулгүй байдлыг хангах, түүнд иргэний нийгмийн оролцоог хангах нөхцөл байдал арай өөр байдаг. ОХУ-ын Аюулгүй байдлын 2020 он хүртэлх стратегид дурдсанаар бол (цаашид стратеги гэх) үндэсний аюулгүй байдал гэдэг бол хувь хүн, нийгэм төрийн эрх, эрх чөлөө хангагдаж, тэдний харилцан холбоотой хөгжил дэвшил баталгаажсан байдлыг хэлнэ [10]. Төрийн үндэсний эрх ашгийн нэг бол “ардчилал, иргэний нийгмийг хөгжүүлэх” [10] явдал юм. Энэ нь Оросын үндэсний аюулгүй байдлын үзэлд ойлголтын чухал алхам болсон юм.



“Аюулгүй байдлын тухай” [8] шинэ хуулиар иргэд ба олон нийтийн байгууллагуудын аюулгүй байдлыг хангах хүрээнд төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох эрхийг баталгаажуулж өгсөн байдаг. Тухайн тохиолдолд хувь хүн иргэний нийгэм нь аюулгүй байдлын объект төдийгүй төрийн болон өөрийн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт идэвхтэй бөгөөд ухамсартайгаар оролцож буй субъект гэсэн логик гаргалгаа хийж болно. Гэвч үндэсний аюулгүй байдлын субъектэд улсын аюулгүй байдлыг хангах хүчин, тухайлбал ОХУ-ын Зэвсэгт Хүчин, бусад цэргүүд, цэрэгжсэн бүрэлдэхүүн, холбооны хууль тогтоомжоор цэргийн болон хууль сахиулах үүрэг бүхий албад, мөн ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу төрийн аюулгүй байдлыг хангахад ороцож буй холбооны төр, засгийн байгууллагууд хамаарагдана [10]. Иргэний нийгмийн институт нь аюулгүй байдлыг хангах хүчний байгууллагатай хамтран ажиллах үндсэн дээр үндэсний аюулгүй байдлыг ханган, “өөрийн хүчин чармайлт, нөөцийг” “оросын иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх”, “эдийн засгийг өсгөх”, “шинжлэх ухаан, технологи, боловсрол, эрүүлийг хамгаалах болон соёлын салбарыг хөгжүүлэх”, “амьд тогтолцооны экологийн орчинг бүрдүүлэх болон байгалийг оновчтой ашиглах” зэрэг зарим тэргүүлэх салбарт төвлөрүүлэхэд анхаардаг байна [мөн тэнд].

Стратеги болон “Аюулгүй байдлын тухай” хуулинд иргэний нийгэм нь үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төр, засгийн гаргах шийдвэрт нөлөөлөх потенциал эрхтэй хуульчилсан байдаг боловч эрх зүйн механизмыг тодорхой зааж өгөөгүйн улмаас иргэний санал санаачилгыг цаашид хөгжүүлэн дэмжих үйл явцад зарим талын хүндрэл бэрхшээл гарч байдаг. Тиймээс төр болон нийгмийн харилцан үйлчлэлийн зохих технологийг боловсруулж, тэдгээрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх шаардлагатай байгаагийн дээр энэ асуудлыг амжилттай шийдвэрлэхийн

тулд ардчилсан улсуудын туршлагад тулгуурлан оюуны төвүүд, бүтээлч бүлгүүдийг байгуулах ажлыг урамшуулан дэмжих учиртай. Судалгаа шинжилгээний болон шинжээчийн асуулгаас үзэхэд ОХУ нь хэнээс ч хамааралгүй судалгаа шинжилгээний төв, олон нийтийн байгууллагыг үүсгэн байгуулж, нэг талаас үндэсний аюулгүй байдлын чиглэлээр шийдвэр боловсруулах ажлын оюуны хангалтын үүргийг хүлээлгэх, нөгөө талаас энэ үйл явцад тавих олон нийтийн хяналтын хүч хэрэгсэл болгох шаардлагатай байгааг ойлгох болжээ [6]. Тэр тусмаа Орос оронд иргэний нийгэм төлөвшин хөгжих боломж хангалттай байгаа юм. ОНСБСБОТ (Олон нийтийн санал бодлыг судлах бүх оросын төв)-ийн мэдээгээр бол 2014-2015 онд сүүлийн гурван жилийн хугацаанд оросын хоёр иргэн тутмын нэг нь сан дурын үндсэн дээр ямар нэг шан харамжгүйгээр нийгмийн ашиг тусын төлөө хөдөлмөрлөсөн байна.

Шинэ нөхцөл байдал үүсч, төрийн бус секторын идэвх өсч байгаа өнөө үед зарим улсын төр засгийн байгууллагууд аюулгүй байдлыг хангахад эзэлж байсан хуучин байр сууриа сэргээхийг эрмэлзэн, иргэд болон нийгмийн хэсэг, бүлгийн үйл ажиллагааг хязгаарлахыг санаархах болов. Гэсэн хэдий ч Т.Карозерс “төрийн бус байгууллагуудын сайтар зохицуулагдсан ажил нь төр, засгийн чадавхийг сулруулдаггүй” гэж тэмдэглэжээ. Төрийн бус байгуулага хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлаар явуулсан өөрийн идэвхтэй үйл ажиллагаагаараа АНУ-ын экологийн бодлогод нөлөөлж, үүний үр дүнд байгаль хамгаалах төрийн албан газар байгуулагдан, эрх зүйн хариуцлага хүлээлгэх хууль батлагдаж, түүнийг хэрэгжүүлэх механизм бий болсон нь үүний нэг тод жишээ юм [13.26]. Өөрөөр хэлбэл төр болон иргэний нийгэм хамтарч хүчээ нэгтгэн, төрийн зүгээс иргэний нийгмийн институтэд дэмжлэг үзүүлвээс төрийн бодлогыг бүрдүүлэх тал дээр илүү үр дүнд хүрч болдог бөгөөд өөр хоорондоо илэрхий сөргөлдөөнд

ордоггүй гэдгийг харуулж байгаа хэрэг юм. Харин энэ тохиолдолд иргэний нийгэм оршин буй тулгамдсан асуудлыг илрүүлэн тодорхой болгож тэдгээрийг шидвэрлэх хувилбарыг санал болгон, хүн амыг энэ ажилд хамруулж, оролцооны тогтолцоог бүрдүүлж өгдөг байна. Иргэний нийгэм болон төрийн хамтын ажиллагааны олон улсын туршлагыг шинжлээд М.Б.Горный “тэдгээрийн хооронд тодорхой заагдсан, тунгалаг харилцааг тогтоосноор хүн амыг олон нийтийн болон нийгмийн санал санаачилгыг боловсруулж хэрэгжүүлэх үйл хэрэгт татан оролцуулж, эргэх холбооны зарчим, харилцааг бий болгодог” гэж дүгнэсэн байдаг [1.225].

Олон нийтийг “төрийн нууц”: тухайлбал гадаад бодлого, зэвсэгт хүчин, өөр бусад зүйлийн талаар сонирхдог болгохын тулд дэмжин урамшуулдаг байх хэрэгтэй гэж Р.Рорти үзсэн байдаг. Улс орны гадаад ба дотоод аюулгүй байдлын талаарх төрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон түмэнд хүргэн тайлбарлаж байх ёстой. Тэд ч эргээд энэ салбар дахь ажлынхаа үр ашгийн талаарх тайлбар тайланг засгийн газраас шаардах учиртай [19]. Тухайн улсын иргэн улс төрийн бодлого боловсруулж, шийдвэр гаргахад оролцох боломжтой, улмаар гүйцэтгэлд нь хяналттай байх явдал бол ардчилсан улс төрийн тогтолцооны чухал шалгуур мөн. Энэ бол төрийн хямрал, нийгмийн задрал, ардчиллын сөрөг талаас зайлсхийх цорын ганц арга юм. Энэ нөхцөлд иргэний нийгмийн институтууд хүн амын эрэлт хэрэгцээг бодлого, үйл ажиллагаандаа тууштай тусгаж, тэр нь улс орны тогтвортой хөгжил, түүний аюулгүй байдлын эрх ашигт тохирч байгаа эсэхээс олон зүйл шалтгаална.

Төр ардчилсан “тунгалаг” байж, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдлыг хангахыг үнэхээр хүсч туйлын зорилгоо гэж үзэж байгаа бол нийгмийн халамж, хэлбэрдсэн сонгууль зэрэг аар саар зүйлээр аргацаан иргэдээс бултахгүйгээр төрийн бодлогыг бүрдүүлэх үйл явцад тэднийг оролцуулах

шаардлагатай. Иргэний нийгэмтэй түншлэх хүрээнд оросын төр ерөнхий стратегийн ба улс төрийн ерөнхий (нийтлэг) соёлыг нийгэмд бүрдүүлэх шаардлагатай байна. Тэр нь ямар нэг зүйлээс “аюулгүй байх”-ад бус дотоодын “аюулгүй байдал”-ыг баримжаалсан байх ёстой. Ийм хандлага бол шинэ маягийн “аюулгүй төр”, “аюулгүй нийгэм”, “аюулгүй хүн” бий болгон төлөвшүүлэх боломжийг олгож, янз бүрийн аюул заналд илүү хөдлөшгүй бат тогтвортой байж, өөрсдөө ч гэсэн хэн хэндээ аюул учруулахгүй оршин байж суралцах нөхцөлийг бүрдүүлнэ. И.В.Радиков “Зөвхөн тогтвортой байдал, дэг журам төдийгүй, мэдээлэл, улс төр-удирдлагын арга дадлага, хувийн болон хүмүүнлэгийн баримжаа бүхий санаачилгатай, бүтээлч бие хүн” хэрэгтэй болохыг тэмдэглэжээ. Чухамдаа ийм л хүнээс аюулгүй байдлын хувь заяа шалтгаална. Аюулгүй байдлын асуудал бол хүний асуудал, тэр тусмаа өөртөө, нийгэмд, төрд хийх хувийн сонголтыг агуулж байдаг [9.42]. Тийм учраас аюулгүй байдлыг хангах асуудал нь хүн, нийгэм, төрийн тэргүүлэх зорилго, дотоод хэрэгцээ болох ёстой.

Дүгнэлт: Ийнхүү иргэний нийгэм нь тодорхой хувь хүн, нийгэмд бүхэлд нь өөр өөрөөр нөлөөлдөг байна. Өнөөгийн ертөнцөд иргэний нийгэм нь өөрийн эрх ашиг, эрэлт хэрэгцээг бүрдүүлэн, аюулгүй байдлын субъект болж, эргэн тойрондоо нийгэм, улс төрийн шинэ орон зай үүсгэдэг. Хэрэв иргэний нийгэм, төр болон иргэний нийгмийн харилцан үйлчлэл алдагдаж, нарийн зохицуулсан эрх зүйн механизм байхгүй, тэдгээрийн хоорондын зөрчлийг ардчилсан институт шийдвэрлэж чадахгүйд хүрвэл түүнээс гарах гарц нь хүчирхийллийн арга хэмжээ болдог. Үүний зэрэгцээ АНУ-ын туршлагаас үзэхэд ардчилсан механизм ба иргэний нийгэм болон төрийн түншлэлийн загварыг нэгтгэн нийлүүлж, хувь хүмүүсийн өөрсдөө зохион байгуулагдсан төрөл бүрийн хэлбэрийн тогтолцоо ба иргэний хяналтаар дамжуулан



үндэсний аюулгүй байдлын асуудлыг үр ашигтай шийдвэрлэж болдог. Энэ нөхцөлд иргэн ба төр, төрийн байгууллага ба иргэний нийгмийн институт харилцааны шинэ соёлыг төлөвшүүлэх стратеги, үр бүтээлтэй яриа хэлцэл, тохиролцоо нэн чухал байдаг. Ийм түншлэлийн харилцаа нь аюулгүй байдлын социаль асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний үр дүнг дээшлүүлдэг байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. **Горный М.Б.** Взаимодействие некоммерческих организаций и органов власти: сравнительный анализ законодательства // Журнал исследований социальной политики. 2010. тал 9. № 2. хуудас. 219-231.
2. **Добровольчество в России: потенциал участия молодежи** [Электронный ресурс]: пресс выпуск ВЦИОМ №1785. URL: <http://wciom.ru/index.php?id=459&uid=111713> (дата обращения: 01.09.2012).
3. **Крауч К.** Постдемократия. М: Изд. Высшей школы экономики, 2010. 192 с.
4. **Макферсон К.** Жизнь и времена либеральной демократии. М.: Изд. дом Гос. ун-та - Высшей школы экономики, 2011. хуудас 174.
5. **Мунтян М. А.** Гражданское общество в свете теории политической науки [Электронный ресурс]. URL: <http://viperson.ru/wind.php?ID=276123> (дата обращения: 02.09.2012).
6. **Национальная безопасность России в оценках экспертов (аналитический отчет по результатам экспертного опроса)** [Электронный ресурс]. URL: http://www.vestnik.isras.ru/files/File/Gorshkov_analit_otchet.pdf (дата обращения: 02.09.2012).
7. **Никовская Л. И.** Гражданское общество и протесты: что за ними стоит? [Электронный ресурс] // Мониторинг общественного мнения. 2012. № 4 (110). URL: http://wciom.ru/fileadmin/Monitoring/110/2012_110_01_nikolskaya.pdf (дата обращения: 14.09.2012).
8. **О безопасности** [Электронный ресурс]: Федеральный закон от 28 декабря 2010 г. № 390-ФЗ. URL: <http://www.rg.ru/2010/12/29/bezopasnost-dok.html> (дата обращения: 03.09.2012).
9. **Радиков И. В.** Безопасность человека: реальность или фикция? // Безопасность человека в контексте международной политики: вопросы теории и практики: материалы научного семинара. М.: Изд. Московского университета, 2011. хуудас 30-44.
10. **Стратегия национальной безопасности РФ до 2020 года** [Электронный ресурс]. URL: <http://www.scrf.gov.ru/documents/99.html> (дата обращения: 01.05.2012).
11. **Сунгуров А. Ю.** Модели взаимодействия власти и гражданского общества [Электронный ресурс]. URL: http://www.civisbook.ru/files/File/Sungurov_modeli.pdf (дата обращения: 03.09.2012).
12. **Токвиль А. де.** Демократия в Америке / пер. с франц.; предисл. Гарольда Дж. Ласки. М.: Весь Мир, 2000. хуудас 560
13. **Carothers T.** The Concept of Civil Society Is a Recent Invention [Электронный ресурс]. URL: <http://www.carnegieendowment.org/pdf/CivilSociety.pdf> (дата обращения: 03.09.2012).
14. **Fernando J., Heston A.** The Role of NGOs: Charity and Empowerment // The Annals of the American Academy of Political and Social Science. Thousand Oaks: Sage Periodical Press, 1997. хуудас 554.
15. **National Security Strategy of the USA. May 2010** [Электронный ресурс]. URL: http://www.whitehouse.gov/sites/default/files/rss_viewer/national_security_strategy.pdf (дата обращения: 01.05.2012).
16. **Post L., Eidlin F.** Civil Society and the Russian Democratic Transition [Электронный ресурс]: APSA 2009 Toronto Meeting Paper. URL: <http://ssrn.com/abstract=1451574> (дата обращения: 03.09.2012).
17. **Putnam R. D., Leonard R., Nanetti R. Y.** Making Democracy Work: Civic Traditions in Mod-



- ern Italy. Princeton University Press, 1993. хуудас 258
18. Riley D. *Civic Associations and Authoritarian Regimes in Inter-War Europe: Italy and Spain in Comparative Perspective* // *American Sociological Review*. 2005. Vol. 70. хуудас 288-310.
 19. Rorty R. *Post-Democracy* [Электронный ресурс] // *London Review of Books*. 2004. Vol. 26. №. 7. хуудас 10-11. URL: <http://www.lrb.co.uk/v26/n07/richard-rorty/post-democracy> (дата обращения: 03.09.2012).
 20. Rothschild E. *What is Security?* // *Daedalus*. 1995. Vol. 124. № 3. хуудас 53-98.
 21. West B. *Protest Movements as Political Strategy* [Электронный ресурс]. URL: <http://www.stratfor.com/weekly/protestmovements-political-strategy> (дата обращения: 03.09.2012)